


**Загвар сургуулиудын багшлахуйн арга
зүйг шинэчлэх, хөгжүүлэхэд чиглэсэн
менежментийн талаар хэлэлцэх илтгэлд
Булган аймгийн Хишиг-Өндөр сумын
сургууль**

Сургалтын менежер Ж .Бямбасүрэн

2013 он



Судалгааны сэдэв:

- Самбарын бичилт,
дэвтрийн бичилтээр багш,
хүүхдийг хөгжүүлэх



Бид Фиүмико Ватари багшийн самбарын бичилтийн энэ зургийг хичээлийн жилийн эхэнд сургуулийн хүндэтгэлийн хэсэгт байрлуулсан. Энэ бол бидний хийхийг хүссэн тэр зүйл

Сэдэв сонгосон шалтгаан

- ▶ 2009–2010 оны хичээлийн жилд “Ээлжит хичээлээр хүүхдийг хөгжүүлэх зорилт тавьсан боловч хичээл доторх элементүүдийн ач холбогдлыг дутуу тооцсон байсанХичээлийн судалгааны явцад багш нарын самбар төлөвлөлт хангалтгүй \багш нар самбар төлөвлөж чадахгүй байсан\, хүүхдийн бичиж тэмдэглэх чадвар ч сул байв.Үүнийг багшийн хичээлийн төлөвлөлт дутуу байгаатай холбож үзсэн.Сайн хичээлээс л сайн самбарын бичилт гарна. Сайн хичээлээр л хүүхэд хөгжинө.Эндээс бид эхний жилийн хичээлийн судалгааны сэдэв хэтэрхий ерөнхий сэдэв байсан байна гэж үзээд энэ хичээлийн жилд ” Багшийг самбарын бичилтээр,хүүхдийг дэвтрийн бичилтээр дамжуулан хөгжүүлэх” зорилтыг дэвшүүлсэн.

Ач холбогдол

- ▶ Самбарын бичилт багшийн хичээлийн зураг төсөл мөн.Самбарын бичилт дэх хүүхэд тус бүрийн санаа бодол нь зарим нь засуулж, зарим нь шууд хүлээн авагддаг.тэдгээр явцыг сурагчдад ил байлгах, бас хүүхэд бүрийн сэтгэж бодсон аргын дарааллыг тодорхой харуулах нь самбарын бичилтийн үүрэг юм.Самбарын бичилт нь хүүхдийн сонсох, бичих, харах, хариулах, бодох, илэрхийлэх гэх мэтийн олон янзын үйл ажиллагааг хөтөлдөг.[1]Тиймээс бид багшийн самбарын бичилтээр дамжуулан хичээл хөгжинө,хичээлээр хүүхэд хөгжинө гэсэн үр дүнг тооцоолсон

Сэдвийн зорилго

- ▶ Бид хүүхдэд ээлжит хичээл дээр мэдлэг бүтээх боломж олгохоос гадна хүүхдийн бичих, унших, ярих, сонсох, чадварыг чухалчилсан. Энэ чадварыг хөгжүүлэхэд багшийн хичээл зохион байгуулах чадвараас гадна багшийн самбараар дамжуулан хүүхэд удирдах чадвар их чухал гэж үзсэн. Яагаад гэвэл хүүхдүүд самбараар дамжуулан өөрийн бодол санаагаа бусадтай хуваалцах, бусдын чухал санаануудыг дэвтэртээ бичиж авах, эргээд дэвтрийн тэмдэглэлээ ашиглан өмнөхийг сэргээн санах боломжтой болсноор тэдний бодож сэтгэх, хандлага болон өөрсдийгөө илэрхийлэх чадвар нь сайжирна гэж үзсэн.

Сонгосон судлагдахуун

- ▶ Энэ хичээлийн жилд дунд ангийн математик, физик, хими, мэдээлэл зүй, бага ангийн математик, хүн орчин, хүн байгаль, төсөлт ажил гэсэн 8 судлагдахуунаар хичээлийн судалгаа хийснээс гадна багш нарын ээлжит хичээл бүрээр багшийг самбарын бичилтэд, хүүхдийг дэвтрийн бичилтэд суралцуулахыг чухалчилсан. Самбар бол тухайн хичээл дээр багш хүүхдүүдийн аль, алиных нь эзэмших талбар байх ёстой гэдэг хандлагын өөрчлөлтийг хийхийг зорьсон. Өөрөөр хэлбэл зөвхөн багш л самбарт бичдэг уламжлалт сэтгэлгээг өөрчлөхийг хүссэн .

Хамрах хүрээ

- ▶ 2–9 дүгээр ангийн 413 сурагч ,бага ,дунд, ахлах ангийн 33 багш ,захирал сургалтын менежерүүд хамтран ажилласан.
- ▶ Багш нар хичээлийн судалгааны үндсэн 6 багт хуваагдан ажилласан ба шаардлагатай үед багийн зохион байгуулалтыг өөрчлөх уян хатан менежменттэй байсан

Сайн үр дүн гарахад шаардсан хугацаа

- ▶ Хичээлийн судалгааны сэдвийг хичээлийн шинэ жилийн эхэнд багш нар хэлэлцээд ээлжит хичээлийг хөгжүүлэх гол зүйл нь самбарын бичилт байх юм гэдэг дээр тогтсон. Нөгөө талаар хүүхэд бодол санаагаа цэгцлэх, бусдын санааг өөрийнхтэй холбох, бие биеээсээ суралцах боломжийг багш самбараар дамжуулан хөтлөх, дэвтэрт хүүхэд зэрэгцсэн бичилт хийж сурахыг зорьж ажиллав. Манай сургууль хүүхдийн бичгийн хэв сайтай \гоё бичдэг\ уламжлалтай боловч бидний дэвтрийн бичилт гэж томъёолоод байгаа тийм бичилтийг хүүхдүүд хийж сураагүй, зөвхөн хуулан бичих байдлаар хандаж байсан. Тиймээс бид хүүхдийн сонсох, ярих, бичих, унших чадваруудыг хөгжүүлэхэд самбарын бичилт, дэвтрийн бичилт чухал гэж үзсэн. Хичээлийн жилийн эхний хагас гэхэд эхний үр дүн гарахаар төлөвлөсөн. Шинэ жилийн баяраар самбарын бичилт сайтай багш, дэвтрийн бичилт сайтай анги хамт олныг шалгаруулан урамшуулсан. 100% үр дүнд хүрээгүй ч нааштай хандлагууд харагдаж байсан. 3-р сард хийгдсэн мониторингоор тодорхой үр дүн гарсан байна гэдэг үнэлгээг мэргэжлийн баг өгсөн.

Үйл ажиллагаа

- ▶ Анги бүрийн багш нар хүүхдийнхээ дэвтэрт бичих чадварыг тогтоосон. Дэвтэрт хэрхэн бичилт хийх аргачлалыг багш бүр хүүхдүүдэд зааж, дэвтрийн бичилтэнд хүүхдүүдийг хөтөлсөн.
- ▶ Багш бүр ээлжит хичээлийн хөтөлбөртөө самбарын бичилтээ төлөвлөх, төлөвлөсөн зураглалаараа хичээлээ удирдах. Ингэхдээ хүүхдүүдийн санаа бодлыг аль болох самбарт буулгах. Самбараасаа буцаад хүүхэд санаа бодлоо хуваалцах, ярилцах боломж олгох, багш үүнийг нь хөтлөхөд сургах ажлыг судалгаатай хичээл болон ээлжит хичээл бүрээр хийх

Үйл ажиллагаа

- ▶ Самбарын бичилтэд хичээлийн бүх үе шатанд дараах дөрвөн өнцгөөс анхаарах
Үүнд : 1.Хичээлийн явц харагдахуйц байх
2.Хичээлийн гол санаа харагдахуйц байх.
3.Санаануудыг харьцуулж болохуйц байх
4.Бодоход дөхөм болох санаа агуулагдсан байх[2] гэсэн зарчмыг баримтлан самбарын бичилтийг хөгжүүлэхээр ажилласан.

Үйл ажиллагаа

- ▶ Хүүхдийн дэвтрийн бичилтийг хөгжүүлэхдээ дараах алхмуудыг баримталсан.
- ▶ Үүнд: 1. Самбарт бичсэнийг алдаагүй зөв, цэгцтэй хуулан бичүүлж сургах
- ▶ 2. Өөрийн санаа болдлыг илэрхийлэн дэвтэрт бичүүлж сургах
- ▶ 3. Бусдын хэлснийг товч ойлгомжтой тэмдэглэн буулгаж сургах
- ▶ 4. Сорил туршилтын явцыг зураг, үг, өгүүлбэрээр тэмдэглэн бичиж сургах
- ▶ 5. Дунд ахлах ангид хичээлийн талаарх сэтгэгдлийг бичгээр бичүүлж сургах үйлүүдийг хийсэн.

Үйл ажиллагаа

- ▶ Хүүхдийн дэвтрийн бичилтийг хөгжүүлэх бас нэг чухал зүйл нь дэвтрийн тэмдэглэлийг уншуулан бусдад сонсгох үйл юм. Ингэснээр сурагч улам хариуцлагатай болж ирдэг.
- ▶ Багшийн самбарын бичилтээр урамшуулал тооцох, сурагчдын дэвтрийн бичилтээр нь анги хамт олноор нь урамшуулах ажлуудыг хийсэн.
- ▶ Материаллаг талаасаа бүх анги танхимыг стандарт хангасан зориулалтын самбартай болгосон.

ҮНЭЛГЭЭ

- ▶ Бид сургуулийн хичээлийн судалгааны сэдвээ зөв ,оновчтой сонголт болж чадсан гэж үзэж байгаа.Хичээлийн судалгаа хийх бүрдээ багш самбарын төлөвлөлтөө зөв төлөвлөж, самбарын бичилтээ сайн хийж чадаж байна уу, самбарын бичилтээрээ хүүхдээ удирдан чиглүүлж чадаж байна уу,сурагчдын дэвтрийн бичилт хэрхэн хөгжиж байна гэдэг асуудлыг хичээлийн хэлэлцүүлэгт байнга оруулж байсан.

ҮНЭЛГЭЭ

- ▶ Энэ ажлын үр дүнд багш бүр ээлжит хичээлийн хөтөлбөртөө самбарын бичилтээ төлөвлөдөг, самбарт хүүхдийн санаануудыг тэмдэглэдэг, харилцан ярилцуулдаг, өнгийн шохой хэрэглэн тодотгох санаа, гол ойлголтыг тэмдэглэдэг, самбарт бичсэнээ арилгахгүй байхыг хичээдэг зэрэг олон сайн талуудыг эзэмшсэн. Харин сурагчдын хувьд багшийн самбарт бичсэн бичилтийг дэвтэрт буулгах чадвартай болсон. Багш нар ч үүнд анхаарал хандуулсан. Хичээлийн тэмдэглэл хөтөлдөггүй сурагчийн тоо багассан.

Үр дүн

- ▶ Зарим санаачлагатай багш нар хүүхдийн дэвтрийн бичилтэд тавигдах шаардлагуудыг боловсруулан дэвтэрт нь наалгасан. Хичээл бүрийн дэвтрийн өнгө хавтсыг ялгаатай байхаар сурагчдаар өөрсдөөр нь хийлгэсэн.
- ▶ Зарим судлагдахууны багш нар өөрийн хичээлийн өвөрмөц онцлогтой уялдуулан хүүхэд бүрийн хувийн самбарыг\гар самбар гэж нэрлэдэг.\ сургалтанд ашиглаж байгаа.

Үр дүн

- ▶ Багш нар ээлжит хичээлийн самбарын төлөвлөлтийг заавал хийдэг, шилдэг самбарын бичилтийг сурталчлах болсон.
- ▶ Хичээлийн жилийн эхэнд хийсэн самбарын бичилтийн зураг авалтыг, хичээлийн жилийн эцэст хийсэн зураг авалттай харьцуулахад их өөр дүр зураг харагдаж байгаа нь ямартай ч ойлголт, хандлагын өөрчлөлт гарсныг харуулж байгаа гэж үзэж байгаа.
- ▶ Самбарын бичилт нь хүүхдийн сонсох, хариулах, бодох, гэх мэтийн олон үйл ажиллагааг хөтөлдөг гэдгийг ойлгож авсан.

Үр дүн

- ▶ Багш нар ээлжит хичээлийн самбарын төлөвлөлтийг заавал хийдэг, шилдэг самбарын бичилтийг сурталчлах болсон.
- ▶ Хичээлийн жилийн эхэнд хийсэн самбарын бичилтийн зураг авалтыг, хичээлийн жилийн эцэст хийсэн зураг авалттай харьцуулахад их өөр дүр зураг харагдаж байгаа нь ямартай ч ойлголт, хандлагын өөрчлөлт гарсныг харуулж байгаа гэж үзэж байгаа.
- ▶ Самбарын бичилт нь хүүхдийн сонсох, хариулах, бодох, гэх мэтийн олон үйл ажиллагааг хөтөлдөг гэдгийг ойлгож авсан.

ҮНЭЛГЭЭ


- ▶ Tanii surguul Dear Alimaa san &
Byambasuren san,
Sain baina uu?

Tanii surguulid moitoring khiiged, mashi
ikh


bayarlalaa. Khicheeliin zurag yavuulya. Tanii
surguuliin sambariin bichiglel tokhiromjtoi
baisan gaj, Yaponii Watari bagshi ruu e-
mail yavuulya.

Daraa uulziya.
Sayaka Suzuki

Энэ сэдвээр судалгаа хийхийн өмнө багшийн самбарын бичилт



Багшийн самбарын бичилт судалгааны явцад



Багшийн хичээл,самбарын бичилт




Хичээлийн бэлтгэл судалгаа




Туршилтийн явцыг хүүхдүүд тэмдэглэж байна




5-р ангийн сурагчийн дэвтрийн бичилт



5-р ангийн сурагчийн дэвтрийн бичилт



4-р ангийн ХҮҮХДИЙН ДЭВТРИЙН Бичилт



Иш татсан

- ▶ [1] Ватари Фүмико(2011) “Хичээлийн хөтөлбөр ба самбарын бичилт лекц”
- ▶ [2] 2008 .Токио хот.Фүчүю хотын 3–р бага сургуулийн судалгааны ажлын танилцуулга.